



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АКТ
Дугаар 06

2018 оны 01 сарын 11 өдөр

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас Өлзийт сумын ЗДТГ-ын 2017 оны 03 дугаар улирлын санхүүгийн баримтад завсрын аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Тус сумын уурын зуухыг менежментийн гэрээгээр түрээслэгч “Залаа цагаан” хоршооны 2016 оны 11 дүгээр сард төлсөн 2000,0 мянга, 2017 оны 06 дугаар сард төлсөн 880,0 мянга, 04 дүгээр сард төлсөн 450,0 мянга, 11 дүгээр сард төлсөн 404,0 мянга, нийт 3734,0 мянган төгрөгийн түрээсийн төлбөрийг төсөвт төвлөрүүлээгүй байна.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3 дахь “Татварын бус орлого нь төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн болон орон нутгийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг, төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр, төрийн болон орон нутгийн өмчийг хувьчилсан, худалдсан, түрээслэсний орлого, ... бусад орлогоос бүрдэнэ”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэсэн заалтууд болон 2016 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн сумын ИТХ-ын дарга, “Залаа цагаан” хоршооны дарга нарын хооронд байгуулсан Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг менежментийн 01 тоот гэрээний 3.10-т заасан “Халаалтын хугацаанд ... түрээсийн төлбөрт сард 100,0 мянга, ОНХС-ийн 031452400 /худгийн эрсдэлийн сан/ дансанд 330,0 мянган төгрөгийг сар бүрийн 25-ны дотор тушаана” гэснийг тус тус зөрчсөн байна.

2517039

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх ...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.6 дахь “Төрийн өмчийн байр, эд хөрөнгийг ашиглуулсаны төлбөр болон борлуулсаны орлогыг дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй”, 3.1.7 дахь “Улсад болон байгууллагад хохирол учруулсан төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан” гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “Залаа цагаан” хоршооны төлсөн түрээсийн төлбөрийн 3734,0 мянган төгрөгийг холбогдох буруутай этгээдээр төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.
2. Аудитаар тогтоосон 3734,0 мянган төгрөгийг Төрийн сан дахь бусад татвар хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэх.
3. Аудитаар тогтоосон 3,734,000 төгрөгийн төлбөрийн актыг барагдуулсан тухай баримтыг 2018.02.20-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Өлзийт сумын Засаг дарга Д.Цэдэнсодном, санхүүгийн албаны дарга А.Ариунболд, төрийн сангийн мэргэжилтэн Д.Сайханцэцэг нарт хариуцуулав.

АКТ



1. Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд харууцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

2018 оны 01 сарын 11 өдөр

АКТ
Дугаар 07

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас Өлзийт сумын ИТХ-ын 2017 оны 03 дугаар улирлын санхүүгийн тайланд завсрын аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Ээлжийн амралтын нөхөн олговрыг цалинтай давхардуулж олгосноос ИТХ-ын нарийн бичгийн дарга Д.Нарантуяад 115,321 төгрөгийн цалинг илүү олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх “Ажилтны цалин хөлсийг хийснээр, цагаар, бусад хэлбэрээр хөдөлмөрийн үр дүнд нь тохируулан олгоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх ...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь “Бусдад өгөх төлбөр тооцоог зөрүүтэй тооцоолж олгосон”, 3.1.7 дахь “Улсад болон байгууллагад хохирол учруулсан төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан” гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүү олгосон цалингийн 115,321 төгрөгийг ИТХ-ын нарийн бичгийн дарга Д.Нарантуяагаар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.
2. Аудитаар тогтоосон 115,3 мянган төгрөгийг Төрийн сан дахь бусад татвар хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэх.
3. Аудитаар тогтоосон 117,321 төгрөгийн төлбөрийн актыг барагдуулсан тухай баримтыг 2018.01.30-ний дотор Баянхонгор аймаг дахь

2517042


Төрийн аудитын газарт ирүүлэхийг Өлзийт сумын ИТХ-ын дарга С.Гонгор,
санхүүгийн албаны дарга А.Ариунболд нарт хариуцуулав.

ТОГТООСОН:



АКТ

ЗӨВШӨӨРСӨН:



1. Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АКТ
Дугаар 08

2018 оны 01 сарын 11 өдөр

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2017 оны 03 дугаар улирлын санхүүгийн тайланд завсрын аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. 2017 оны 03 дугаар сард дотуур байрны жижүүр Г.Оюуны цалингийн суутгалыг буруу хийснээс шалтгаалж, ажилтанд 50,000 төгрөгийн цалин дутуу олгосон.

2. У.Удвалыг 2017.09.04-нөөс томилсон шийдвэрийг байгууллагын дарга гаргасан байхад 9 сарын цалинг бүтэн /X/02,X/3- Бямба, Ням гараг/ олгож, 1 өдрийн цалинд 17,668 төгрөгийг илүү олгосон.

3. Сургалтын менежерийн гаргасан илүү цагийн тооцоог үндэслэн илүү цагийн хөлсийг давтан тооцоолоход 11 багшид 299740 төгрөгийн илүү цагийн хөлсийг илүү тооцоолж олгосон, 2 багшид 59199 төгрөгийн илүү цагийн хөлсийг дутуу тооцоолж олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх “Ажилтны цалин хөлсийг хийснээр, цагаар, бусад хэлбэрээр хөдөлмөрийн үр дүнд нь тохируулан олгоно” гэснийг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх ...”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд

2517043

баримтлах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь "Бусдад өгөх төлбөр тооцоог зөрүүтэй тооцоолж олгосон", 3.1.7 дахь "Улсад болон байгууллагад хохирол учруулсан төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан" гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Дутуу олгосон цалингийн 50,000 төгрөгийг Г.Оюунд, дутуу олгосон илүү цагийн нэмэгдлийг 59199 төгрөгийг хавсралтад заасан 2 ажилтанд буцаан олгохоор төлбөрийн акт тогтоов.

2. Илүү цагийн хөлсийг илүү тооцоолж олгосон хавсралтад заасан нэр бүхий 11 ажилтнуудаар 299740 төгрөгийг нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

3. Аудитаар тогтоосон 299,740 төгрөгийг Төрийн сан дахь бусад татвар хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэх.

4. Аудитаар тогтоосон 408,939 төгрөгийн төлбөрийн актыг барагдуулсан тухай баримтыг 2018.02.10-ний дотор Баянхонгор аймгийн аудитын газарт ирүүлэхийг Эрдэнэцогт сумын сургуулийн захирал Ш.Гэрэлмаа, нягтлан бодогч Ү.Банзрагч нарт хариуцуулав.

АКТ

ТОГТООСОН¹:
АХЛАХ АУДИТОР

Б.ДОЛЖМАА
6417143544
БНДА00067 9007423

ЗӨВШӨӨРСӨН:
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Ш.ГЭРЭЛМАА
НЯГТЛАН БОДОГЧ
Ү.БАНЗРАГЧ
61Д0001 9008790

1. Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.